



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016. оны 10 сарын 25 өдөр

Дугаар A/93.

Улаанбаатар хот

Г Аялал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/726 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын 377 жилийн ойг тохиолдуулан Аялал жуулчлалын мэргэжлийг сонгон суралцаж буй нэгдүгээр дамжааны оюутнуудыг хамруулсан хотын түүх, соёл, аялал жуулчлалын үзмэрүүдийг таниулах, нийслэл хотоороо бахархах ухамсар, ойлголтыг өгөх, үйлдвэр аж ахуйн газруудын үйл ажиллагаатай танилцуулах аяллыг 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахыг Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Н.Алтанзаяа/, Мэдээлэл сурталчилгааны төв хариуцсан мэргэжилтэн /П.Баясгалан/ нарт тус тус даалгасугай.

2. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах төсөв 3,315,000 /гурван сая гурван зуун арван таван мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ D.Batsukh
Д.БАТСҮХ

